Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны 4 дугаар улирлын нийт зардлын 1,854,915.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,549.2 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,915,225.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 29,152.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,967,820.8 мянга өмнөх оноос 96,697.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	105,467.0	244,583.9	139,116.9
Мөнгөн хөрөнгө	5,000.0	1,075.0	(3,925.0)
Авлага	7,673.9	1,667.0	(6,006.9)
Бараа материал	92,793.1	241,841.9	149,048.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,224,062.2	1,089,153.9	(134,908.4)
Үндсэн хөрөнгө	1,599,059.8	1,547,076.4	(51,983.3)
Хуримтлагдсан элэгдэл	(374,997.5)	(457,922.6)	(82,925.0)
Нийт хөрөнгө	1,329,529.3	1,333,737.8	4,208.5
Өр төлбөр	-	3,644.5	3,644.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,329,529.3	1,330,093.3	564.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,329,529.3	1,333,737.8	4,208.5

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буюу ахмадын сан нь 1,075.0 мянган төгрөг болж 3,925.0 мянган төгрөгөөр буурсан нь тухайн онд ахмадын санд орлого ороогүй зардал гарснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 1667.0 мянган төгрөг болж 6006.9 мянган төгрөгөөр буурсан нь урд оны нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн 7551.6 мянган төгрөгийн орлогыг авлагаар тусгаж Сангийн яамнаас буцааж авсан ба тайлант онд 1667.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж авлагаар тусгасантай холбоотой байна. шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 241,841.9 мянган төгрөг болж 149,048.9 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 133,487.2 мянга, бичиг хэргийн материал 1,236.1 мянга, аж ахуйн материал 4,615.0 мянга, сэлбэг хэрэгсэл 565.0 мянга, түлш шатах материал 6,913.7 мянга, барилгын засварын материал 784.5 мянга, бусад хангамжийн материал 1,478.2 мянган төгрөг тус тус өссөнтэй холбоотой байна.

Энэ нь эм боох материалын үлдэгдэл 133,487.2 мянган төгрөгөөр өссөн нь тендерийн эмийн үлдэгдэл 42,573.6 мянга, вакцины үлдэгдэл 39,616.7 мянга, ковид 19 өвчин гарсантай холбоотой эм боох материал болон хамгаалах хэрэгсэл нөөцөлсөнтэй холбоотой 66858.6 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,547,076.4 мянган төгрөг болж 51,983.3 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31 өдрийн 51 дүгээр тогтоолоор 68,743.3 мянган төгрөгийн хөрөнгийг Нэгдсэн эмнэлэг, Баян-Өндөр, Эрдэнэцогт, Баянлиг сумдын эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.11.06-ны өдрийн 108 дугаар тогтоолоор 940.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3664.5 мянган төгрөг болж 3664.5 мянган төгрөгөөр өссөн нь "Ази фарм" ХХК-д тендерийн эмийн өглөг үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1327754.3 мянган төгрөг болж 1774.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,916,789.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,027,415.3 мянган төгрөгөөр буюу 54.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1,027,415.3 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилт 572,427.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 205,109.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 249,877.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.



Нийт зардал 2,859,605.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1,004,600.8 мянган төгрөгөөр буюу 54.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, тээвэр шатахуун, эм, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний төлбөр хураамж өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,583,985.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,583,985.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 198,033.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,782,018.9 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь эмийн зардал дээр 5110,0 мянган төгрөг байсныг 234610,0 мянган төгрөг өөрчилж, бусад зардлыг хасаж баталсантай холбоотой байна.

Тайлант онд анх баталсан 1782018,9 мянган төгрөгийг тодотголоор 233,112.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,015,130.9 мянган төгрөгөөр баталсан байна.


Энэ нь эм боох материалыг 70,900.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг Эрүүл мэндийн сайдын 2020.11.20-ны өдрийн А/133 дугаар тушаалаар коронавируст халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангаж ажиллахад сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд үүссэн өр, төлбөрийг барагдуулах, Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байгаа сумдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 162,882.3 мянган төгрөгийг тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,015,130.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,015,130.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,015,130.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,986,677.8 мянган төгрөгийг зарцуулж, 28453.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,986,677.8 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,136.2 мянга, байр ашиглахтай холбоотой зардал 8,748.2 мянга, хангамж, бараа материалын зардал 1,525.4 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 1,140.0 мянга, нормын хувцас, зөөлөн



**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

эдлэл 25.0 мянга, эд хогшил худалдан авах зардал 5,610.1 мянга, томилолт, зочны зардал 1,614.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 103.4 мянга, бусад урсгал шилжүүлэг 7,434.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 71603				
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,015,130,900.00	1,986,677,836.70	28,453,063.30	98.59
УРСГАЛ ЗАРДАЛ	2,015,130,900.00	1,986,677,836.70	28,453,063.30	98.59
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,015,130,900.00	1,986,677,836.70	28,453,063.30	98.59
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	532,253,300.00	531,117,084.00	1,136,216.00	99.79
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,580,900.00	66,580,898.01	1.99	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,660,300.00	79,912,056.38	8,748,243.62	90.13
Хангамж, бараа материалын зардал	37,913,800.00	36,388,382.72	1,525,417.28	95.98
Нормативт зардал	307,010,000.00	305,869,999.30	1,140,000.70	99.63
Эд хогшил, урсгал засварын зардал	25,387,600.00	19,777,465.00	5,610,135.00	77.90
Томилолт, зочны зардал	8,075,000.00	6,461,000.00	1,614,000.00	80.01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,189,000.00	12,085,581.29	103,418.71	99.15
Бараа үйлчилгээний бусад зардал	188,713,300.00	188,070,000.00	643,300.00	99.66
ХӨТӨЛБӨР 71603			0.00	0.00
АРГА ХЭМЖЭЭ 80802			0.00	0.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	726,851,400.00	719,416,686.00	7,434,714.00	98.98
Бусад урсгал шилжүүлэг	726,851,400.00	719,416,686.00	7,434,714.00	98.98
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	349,172,200.00	343,582,886.00	5,589,314.00	98.40
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	6,554,600.00	1,845,400.00	78.03
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	369,279,200.00	369,279,200.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71603			0.00	0.00
АРГА ХЭМЖЭЭ 83112			0.00	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,496,300.00	20,998,684.00	497,616.00	97.69
УРСГАЛ ЗАРДАЛ	21,496,300.00	20,998,684.00	497,616.00	97.69
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,496,300.00	20,998,684.00	497,616.00	97.69
Бараа үйлчилгээний бусад зардал	21,496,300.00	20,998,684.00	497,616.00	97.69

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн ивээх сангаас төсөл хөтөлбөрийн 135,117.0 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс эрүүл мэндийн байгууллагын төрийн албан хаагчийн орон сууц, хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд 100,000.0 мянга, Эрүүл мэндийн яамнаас өвөлжилт хүндрэлтэй сумууд, ковид 19 өвчинтэй холбогдуулан гарах зардалд дэмжлэг үзүүлэх, Эрүүл мэндийн байгууллагад ковид 19 сэргийлэлт хяналт эмнэлгийн бэлэн байдалд үнэлгээ хийх зэрэгт 38,083.4 мянга, Улсын төсвөөс урьд оны өр барагдуулах 7551.6 мянга, цахим тендерийн орлого 630.0 мянга, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа



эрчимжүүлэх, хөгжүүлэхэд 3000.0 мянга, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьцын тээвэрлэлт, сүрьеэ өвчнийг илрүүлэх зардалд 10589.5 мянга, тусгай зөвшөөрлийн орлого 3436.0 мянга, шүүхийн шийдвэрээр урьд оны эмийн үнээс 28680.6 мянга, сумдаас 2019 оны тендерийн эмийн өглөг 8952.3 мянга, 2020 оны эм ханган нийлүүлэгч байгууллагад төлөх тендерийн эмийн үнэ сум дундын 3 эмнэлгээс 30814,6 мянган төгрөг орж, нийт 366855.1 мянган төгрөгийн орлого төвлөрч 364856.6 мянган төгрөгийг холбогдох шийдвэрийн дагуу зарцуулж, үлдэгдэл 1998.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан 141,505.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулсан эсэхийг хянаж үзэхэд орлогын 41 гүйлгээний 2,334,332.0 мянга, зарлагын 14 гүйлгээний 2,415,181.5 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулсан.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9			2
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	95	1		
6	Нийт	27	151	148	1		2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нийт 50391.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10541.5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 2150.0 мянган төгрөгийн албан шаардлага, 37699.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Аудитаар өгсөн 26,219.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2020.03.02-ны өдрийн 133 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт



**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	10,541.5	2	10,541.5			
Албан шаардлага	1	2,150.0	1	2,150.0			
Зөвлөмж	5	37,699.9	5	37,699.9			
Нийт дүн	8	50,391.4	8	50,391.4			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,439.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3881.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 54,705.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,602.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 2249.0 мянган төгрөгийг бараа материалыг орлого авч санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн Онцгой комиссоос 8,929.0 мянган төгрөгийн маск, хамгаалалтын хувцас, зайнаас халуун хэмжигч өгснөөс маск, хамгаалалтын хувцсыг орлого авч 13 ширхэг нэг бүрийн үнэ 173.0 мянган төгрөгийн өртөгтэй 2,249.0 мянган төгрөгийн зайнаас халуун хэмжигчийг орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2."Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд орлогоор бүртгэж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 60,190.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 54,705.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3881.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1602.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв. Үүнд:

1. Эрүүл мэндийн газрын даргын 2020.11.20-ны өдрийн А/126 дугаар тушаалаар "Бүх нийтийн бэлэн байдалтай шилжсэнтэй холбоотой Эрүүл мэндийн албаны штаб болон мэргэжлийн бие бүрэлдэхүүнд тус байгууллагаас ажиллаж буй эмч эмнэлгийн ажилтнуудад 2864.0 мянган төгрөгийг тухайн сарын хоолны мөнгөтэй давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох



2. Эрүүл мэндийн газрын 2020 оны оны шилдэг ажилтнаар шалгарсан шалгарсан 2 албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1554.6 мянган төгрөгийн урамшуулал, Эрүүл мэндийн яамнаас 4000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосныг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зарцуулах эрх олгон эрүүл мэндийн ажилтнуудад олгохдоо ХХОАТ суутгаагүй, 1750.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт, 2870.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшууллыг олгохдоо ХХОАТ тус тус суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3."Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно" 6.3.1."Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3.Тайлант онд сумын эрүүл мэндийн төвүүдийн эмийн зардал аймгийн Эрүүл мэндийн газрын төсөвт нэмэгдэж батлагдсан ба эмийн тендер зарлагдаж 266539.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 239782.3 мянган төгрөгийн эмийг сумдын Эргэлтийн эмийн санд олгосон байна. Сумдын эргэлтийн эмийн сангаас сумын ЭМТ-үүд захиалгын дагуу эмийг авч байгаа ба үлдэгдэл 54,154.6 мянган төгрөгийн тооцоог ирүүлсэн боловч аудитын явцын цаг хугацааны байдлаас шалтгаалан сумдын эмийн сан нь хувийн аж ахуйн нэгж болсонтой холбогдуулан аудитад хамрагдахгүй байгаа тул үлдэгдэл эмийг тоолох, бүрэн нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.6."Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Эрүүл мэндийн газрын дарга В.Нарантуяагийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 66 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын төвийн дарга С.Баасанхүүг ажлаас чөлөөлсөн ба Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.04.10-ны өдрийн 131/ШШ2019/00310 дугаар захирамжаар иргэнд ажилгүй байсан хугацааны 551.3 мянган төгрөгийг НДШ-ийг төлүүлэх шийдвэр гарч тухайн байгууллагын төсвөөс 2020 оны 01 дүгээр сарын 29-нд төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх



Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн ЭМГ-т эмийн зардлыг нийт 305,510.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна. Үүнийг тодруулан шалгахад сумдын ЭМТ-ийн эмийн зардал өмнөх оноос бууруулан төсөв батлагдсанаас аймгийн ЭМГ -т эмийн зардлыг баталсан байна.

Аймгийн ЭМГ нь эмийн тендерийн үйл ажиллагааг зохион байгуулж эмийн худалдан авалтыг хийж 239,782.3 мянган төгрөгийн эмийг олгосноос Сум дундын 3 эмнэлэгт 34,716.0 мянга, 19 сумдад 205,066.3 мянган төгрөгийн олгож сумдын ЭМТ нь үнэ төлбөргүй орлогоор бүртгэж харин сум дундын эмнэлгээс 30,814.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч ААНБ-га руу эмийн үнэнд шилжүүлж эмийн үнийг төлсөн байна. Мөн Богд сумын СДЭ 2,255.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсныг тухайн байгууллага санхүүгийн тайланд тусгасан.

Сумдын ЭМТ-дэд олгосон эмийн түүврийг хийж шалгахад дээрх тендерийн олгосон эмээс 64,372.1 мянган төгрөгийн эм нь сумдын эмийн санд үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Богд сумын СДЭ 2,255.2 мянга, Баянлиг сумын ЭМТ 3,023.4 мянга, Гурванбулаг сумын ЭМТ 4,938.8 мянга, нийт 10,217.4 мянган төгрөгийн эмийг орлого авч үлдэгдлээр санхүүгийн тайландаа тусгасан, бусад сумд 54,154.7 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Сумын нэр	Татан авсан дүн	Үлдэгдэл	Сумын нэр	Татан авсан дүн	Үлдэгдэл
Баянбулаг	12,924.8	1,614.8	Баянцагаан	13186.0	3314.3
Баянговь	14,976.4	8,488.6	Заг	10285.2	1536.8
Галуут	12,044.8	1,525.1	Шаргалжуут	7194.4	1916.8
Баян-Овоо	13,945.4	3,575.1	Бөмбөгөр	10565.2	1769.8
Шинэжинст	17,052.5	8,004.3	Бууцагаан	6487.1	
Баян-Өндөр	10,610.7	2,162.1	Хүрээмарал	12913.1	6726.6
Өлзийт	16,784.3	4,715.8	Баацагаан	13476.0	4235.9
Эрдэнэцогт	10,723.4	2,884.8	Жаргалант	9442.5	1060.5
Жинст	10,819.1	623.4	Талын дүн	83549.4	20560.8
Талын дүн	119,881.5	33,593.9	Нийт дүн	203430.8	54154.7

Дээрх санхүүгийн тайланд тусгаагүй эмийн үлдэгдлийн тооллогыг хийж, авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, эмийн аюулгүй байдал, хэрэгцээг судалж, эмийн солилцоо хийх, шаардлагагүй эмийг буцаан аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн ЭМГ-т хүргүүлэв.

Иймд Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эмийн зардлыг Эрүүл мэндийн газраар дамжуулан төлбөр тооцоог хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2."Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтыг зөрчиж байгаа тул цаашид эмийн

зардлыг сумдын Эрүүл мэндийн төвөөр дамжуулж зарцуулж байх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 Илрүүлэлт

Сумдын ЭМТ-дэд олгосон эмийн түүврийг хийж шалгахад дээрх тендерийн олгосон эмээс 64,372.1 мянган төгрөгийн эм нь сумдын эмийн санд үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Богд сумын СДЭ 2,255.2 мянга, Баянлиг сумын ЭМТ 3,023.4 мянга, Гурванбулаг сумын ЭМТ 4,938.8 мянга, нийт 10,217.4 мянган төгрөгийн эмийг орлого авч үлдэгдлээр санхүүгийн тайландаа тусгасан, бусад сумд 54,154.7 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

1.2. Эрсдэл

Хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байх

1.3 Өгсөн зөвлөмж

Санхүүгийн тайланд тусгаагүй эмийн үлдэгдлийн тооллогыг хийж, авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, эмийн аюулгүй байдал, хэрэгцээг судалж, эмийн солилцоо хийх, шаардлагагүй эмийг буцаан аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.1 Илрүүлэлт

Төсвийн хөрөнгөөр 1602.9 мянган БҮТЭЗ худалдан авч "Их богд" эмнэлэг, "Наян булаг ганга" эмийн сангуудад шинэ байр ашиглалтад орсонтой холбогдуулан, Өлзийт сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт зэрэг байгууллагын нээлтийн үйл ажиллагаанд бэлэглээд дараа Эрүүл мэндийн газрын даргын 2020.12.31-ны өдрийн А/175 дугаар тушаал гарган шилжүүлсэн байдлаар зарлагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.10."Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

2.3 Өгсөн зөвлөмж

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж төсвийг үрэлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.5. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Н.Бунчинсүрэн

Н.БҮНЧИНСҮРЭН
ОГНОО: 2021.02.23

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.23

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.23

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БНА-2021/163/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Аймгийн Онцгой комиссоос 8,929.0 мянган төгрөгийн маск, хамгаалалтын хувцас, зайнаас халуун хэмжигч өгснөөс маск, хамгаалалтын хувцсыг орлого авч 13 ширхэг нэг бүрийн үнэ 173.0 мянган төгрөгийн өртөгтэй 2,249.0 мянган төгрөгийн зайнаас халуун хэмжигчийг орлого аваагүй байна.	2,249.0	Санхүүгийн тайланд залруулга хийх	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
2	Эрүүл мэндийн газрын даргын 2020.11.20-ны өдрийн А/126 дугаар тушаалаар "Бүх нийтийн бэлэн байдалтай шилжсэнтэй холбоотой Эрүүл мэндийн албаны штаб болон мэргэжлийн бие бүрэлдэхүүнд тус байгууллагаас ажиллаж буй эмч эмнэлгийн ажилтнуудад 2864.0 мянган төгрөгийг тухайн сарын хоолны мөнгөтэй давхардуулан олгосон байна.	2864.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
3	Албан хаагчдад олгосон 10174,6 мянган төгрөгийн урамшуулал, түлшний хөнгөлөлт, тэтгэмжийн зардлаас ХХОАТ суутгаагүй байна.	1017.5	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
4	Тайлант онд сумын эрүүл мэндийн төвүүдийн эмийн зардал аймгийн Эрүүл мэндийн газрын төсөвт нэмэгдэж батлагдсан ба эмийн тендер зарлагдаж 266539.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 239782.3 мянган төгрөгийн эмийг сумдын Эргэлтийн эмийн санд олгосон байна. Сумдын эргэлтийн эмийн сангаас сумын ЭМТ-үүд захиалгын дагуу эмийг авч байгаа ба үлдэгдэл 54,154.6 мянган төгрөгийн тооцоог ирүүлсэн боловч аудитын явцын цаг хугацааны байдлаас шалтгаалан сумдын эмийн сан нь хувийн аж ахуйн нэгж болсонтой холбогдуулан аудитад хамрагдахгүй байгаа тул үлдэгдэл эмийг тоолох, бүрэн нотлох боломжгүй байна	54,154.6	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ

**Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	<p>Эрүүл мэндийн газрын дарга В.Нарантуяагийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 66 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын төвийн дарга С.Баасанхүүг ажлаас чөлөөлсөн ба Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.04.10-ны өдрийн 131/ШШ2019/00310 дугаар захирамжаар иргэнд ажилгүй байсан хугацааны 551.3 мянган төгрөгийг НДШ-ийг төлүүлэх шийдвэр гарч тухайн байгууллагын төсвөөс 2020 оны 01 дүгээр сарын 29-нд төлсөн байна.</p>	551.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
6	<p>Сумдын ЭМТ-дэд олгосон эмийн түүврийг хийж шалгахад дээрх тендерийн олгосон эмээс 64,372.1 мянган төгрөгийн эм нь сумдын эмийн санд үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Богд сумын СДЭ 2,255.2 мянга, Баянлиг сумын ЭМТ 3,023.4 мянга, Гурванбулаг сумын ЭМТ 4,938.8 мянга, нийт 10,217.4 мянган төгрөгийн эмийг орлого авч үлдэгдлээр санхүүгийн тайландаа тусгасан, бусад сумд 54,154.7 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.</p>		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
7	<p>Төсвийн хөрөнгөөр 1602.9 мянган БҮТЭЗ худалдан авч "Их богд" эмнэлэг, "Наян булаг ганга" эмийн сангуудад шинэ байр ашиглалтад орсонтой холбогдуулан, Өлзийт сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт зэрэг байгууллагын нээлтийн үйл ажиллагаанд бэлэглээд дараа Эрүүл мэндийн газрын даргын 2020.12.31-ны өдрийн А/175 дугаар тушаал гарган шилжүүлсэн байдлаар зарлагдсан байна.</p>	1602.9	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Энхжаргал П.Мөнх-Эрдэнэ
ДҮН		62,439.3			